



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХҮРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

Дугаар 01

Огноо 2018.04.26

Хувь нийлүүлэгчдийн хурал 16:00 цагаас Баянгол рестораны зааланд эхлэв.

Хуралд: ТҮЗ-ын гишүүн Б.Аюуш, ТҮЗ-ын гишүүн Ц.Хэнмэдэх, ТҮЗ-ын гишүүн Цэндбаяр, ТҮЗ-ын гишүүн З.Цэрэнчимэг нар хүрэлцэн оролцлоо.

Тооллогын комиссын дарга Т.Бичигмаа: Комиссын тогтоолыг танилцуулж 80.1 хувийн ирцтэйгээр хурлыг нээв.

ТҮЗ-н гишүүн Б.Аюуш: ТҮЗ-н дарга Батжаргал томилолтоор явсан тул хурлыг ТҮЗ-н гишүүн Б.Аюуш миний хурлыг удирдан явуулна.

Хурал эхлэхийн өмнө та бүхэнд саналын хуудасаа хэрхэн бөглөх талаар зааварчлала өгье.

ТҮЗ-ын гишүүдэд санал өгөхдөө:

1. Саналын хуудасны ард хэрхэн бөглөх талаар тайлбар бичсэн байгаа түүнтэй танилцах
2. Кумулятив аргаар санал өгөх ёстой. Энэ арга нь хувьцааны тоогоо 9 өөр үржүүлж ердийн гишүүдэд 3/2 ыг хувааж, хараат бус гишүүдэд 3/1 ийг хувааж саналаа өгнө шүү.

Одоо хурлаар хэлэлцэх асуудалдаа орёе.

Энэ удаагийн Хувь эзэмшигчдийн хурлаар 3 асуудал хэлэлцэхээр ТҮЗ-ийн хурлаар шийдвэрлэсэн байна.

Үүнд:

1. 2017 оны Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангын талаарх ТҮЗ-н дүгнэлтийг хэлцэж батлах
2. ТҮЗ-н 2018 оны төсвийг батлах
3. ТҮЗ-н гишүүдийг сонгох тухай

ТҮЗ-н дүгнэлтийг сонсохын өмнө 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангын талаарх гүйцэтгэх удирдлагаас та бүхэнд бэлдэж толиглуулсан материалыг тараасан байгаа, энэ материалаас гадна одоо дэлгэцэн дээр үйл ажиллагааны тайлангын талаарх мэдээллийг ерөнхий нябо Бичигмаа, эдийн засагч Лхагваа нар хүргэнэ.

Ерөнхий нягтлан Т.Бичигмаа: 2017 оны санхүү үйл ажиллагааны тайланг дэлгэцнээс харна уу. Та бүхэнд танилцуулъя.

ЭРХЭМ ЗОРИЛГО

"БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ" ХК-НЫ ЗОЧИДОО ДЭЭДЭЛСЭН, ЗОЧИН БҮРТЭЭ ЧИН СЭТГЭЛЭЭСЭЭ ҮЙЛЧИЛДЭГ БАЙГУУЛЛАГА БАЙНА.

АЛСЫН ХАРАА:

"Баянгол зочид буудал" ХК нь зочлохуйн үйлчилгээний салбарт тэргүүлэх чиглэл баримтлан, гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллаж, олон улсын үйлчилгээний стандарт, дэвшилтэт шинэ үйлчилгээ, техник төхөөрөмж ашиглан, чадварлаг баг, ажилтантайгаар "Баянгол бренд" - ийн үйлчилгээг бүт болгоно.

КОМПАНИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Баянгол Зочид буудал нь 360 зочин хүлээн авах, таван ангилалын 211 өрөө, 300-450 хүн хүлээн авах боломжтой Баянгол ресторан, Монголын нэг өдөр ресторан, Ази-Европ хоолны ресторан, дээд зэрэглэлийн виноны Wine House кафе-бар, зочны угаалга, ерөөний үйлчилгээ, үсчин гоо сайхан, интернэт зэрэг 20 гаруй төрлийн дарагдах үйлчилгээг зочдоод үзүүлж байна.

Орлого үр дүнгийн талаар:

Тайлангийн хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлого 2016 оноос 14%-иар, төлөвлөсөнөөс 1%-иар өссөн, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 7%-иар өсөж улмаар үйл ажиллагааны ашиг 24%-иар өсөж, дүнджаар 160 аад ажиллагсадтай үйл ажиллагаагаа явуулж, зочид гийчдэдээ үйлчиллээ.

Зочид буудал, рестораны салбарын хувьд 2017 онд Holiday inn, Ibis Styles Ulaanbaatar Polaris, Зүчи, Khuvsgul lake, Premium palace, Royal Mountain, Xandu зэрэг гадаад дотоодын хөрөнгө оруулалттай зочид буудлууд шинээр үүд хаалга нээсэн, цаашид ч Tokyo inn, Novotel зэрэг олон улсын сүлжээ буудлууд нээгдэх гэж байгаа нь зочид буудлын салбарын зах зээлийн өрсөлдөөнийг улам нэмэгдүүлж байна.

Хүний нөөцийн талаар:

"Баянгол зочид буудал" ХК нь зочид буудлын салбараас анх удаа үйлчилгээний салбарын ажилтнуудыг аттестатчлах үйл ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Зочид буудлын холбоотой хамтран амжилттай зохион байгуулсан ба үүний үр дүнд 2017 онд ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж өмнөх онтой харьцуулахад 26 хувиар өссөн байна.

Энэ 2018 ондоо бид олон улсын чанарын удирдлагын ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх зорилтыг дэвшүүлээд байна.

Байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд төлөвлөгөөний дагуу хийсэн ажлууд:

- ✓ Ажилчдыг ажлын үр дүнгээр урамшуулах урамшуулал болон шагналт цалинд 118.0 сая.төгрөг
- ✓ Ялсны зүрх судасны эмгэг согогийн нарийн мэргэжлийн эмч нарт 20.0 гаруй сая.төгрөг-ийн дэмжлэг үзүүлсэн.
- ✓ "Женко-34" жудо бөхийн клубийн тамирчдыг дэмжиж ажилласан

✓ Ажилчид болон өндөр настан түүний ар гэр, эрүүл мэндэд, буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэхэд 35.0 сая.төгрөг зарцуулсан

✓ Ажилчдын шинэ жил, оны тэргүүний ажилчдын шагнал, гадаад аялал, олон улсын мэргэжлийн уралдаан тэмцээнд амжилттай оролцсон ажилчдад шагнал гэх мэт 55.0 сая.төгрөг зарцуулсан

✓ Цагаан сар болон ахмадын өдрийг тохиолдуулан ахмадуудаа хүлээж авч хүндэтгэл үзүүлэхэд 11.5 сая.төгрөг

✓ Биеийн тамир олон нийтийн арга хэмжээнд 8.2 сая.төгрөг

✓ 2017 онд ажилчдын нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээнд 7.8 сая.төгрөг-ийн зардлыг тус тус зарцуулсан.

2018 ОНЫ КОМПАНИЙН ЗОРИЛТО

Зочид гийчдийн тав тухтай орчныг бүрдүүлж, байгууллагын гадна, дотор засвар тохижилт, тавилга, төхөөрөмжүүдээ шинэчлэх ажилд хөрөнгө оруулалт хийн, мэргэжлийн туршлагатай MPTSCSH бар – хамт олон үйлчлүүлэгч бүрийн сэтгэлд нийцсэн шинэлэлт үйлчилгээгээрээ бүүдлын ор амжилтыг бүрдүүлэхгүйгээр, борлуулалтын нийт орлогыг 7.4 тэрбум төгрөг болгож, татварын өмнөх ашгийг өнгөрсөн оны хэмжээнд байлгаж, " ISO 9001:2015 чанарын стандарт"-ыг нэвтрүүлнэ.

2017 ОНЫ КОМПАНИЙН ЗОРИЛУУД

НЭГДҮГЭЭР ЗОРИЛТ: Борлуулалт, Маркетинг, зочны үйлчилгээнд шинэ бүтээгдэхүүн, бодит үнэ хэрэгжүүлнэ;

- 2018 оны Борлуулалт, маркетингийн төлөвлөгөө боловсруулах
- Зах зээл, үйлчилгээнд нийцсэн үнийн санал гаргаж хэрэгжүүлэх
- Хөнгөлөлт, урамшуулал, цдөөхжүүлэлтийн хөтөлбөр, сар улирлын хуваарьтай гаргаж мөрдөж ажиллах
- Зочид бүүдлын захиалгын On-line сайтуудыг ажиллагааг сайжруулах
- Шинэ үйлчилгээ гаргах, Багц бүтээгдэхүүний олон төрлийн уян хатан гаргах
- Зочны үйлчилгээнд эрүүл, тохилог аюулгүй орчинг бүрдүүлж өгөх
- Компанийн дагуу малаа ашиглах боломж, судалгаа хийх, хэрэгжүүлэх
- Хуучин харилцагчдаа татах, тэдэнд шинэ багц, нэмэлт үйлчилгээ санал болгох
- Гэрээт байгууллага, харилцагчийн тоог нэмэгдүүлэх
- Өөрийн нэрийн зарим бүтээгдэхүүнд "патентийн эрх" авах, "BG" лого нь барааны эрх авах

ХОЁРДУГААР ЗОРИЛТ: Өрмөг зардалыг хямдруулж, бодит хэмнэлт гаргана:

- Орлого нэмэгдүүлэх эх үүсвэрийг судлаж төлөвлөх
- Орлого, зарлагаа маркетингийн төлөвлөгөө, өмнөх жилүүдийн судалгаанд үндэслэн тоон үзүүлэлтээр төлөвлөж, сар үйлдлийн хуваарь хийх
- Зардлыг нэр мөрөл, алба нэгж бүрээр сүүлийн 3 жил, 2017 оны төлөвлөгөөтэй харьцуулсан судлагаа хийж, дүгнэлт хийх, зардлыг зохистой хэмнэх ажил зохион байгуулж, тогтмол болон урсгал зардлын зохистой хэрэглээг бий болгох
- Бүтэц орон тоог оновчтой болгож, түүнд тохирсон цалин урамшуулалыг тогтоцоог бий болгох

ГҮРЭВДҮГЭЭР ЗОРИЛТ: Ажилчдын нийгмийн асуудал, хөгжил, сургалт:

- ISO 9001:2015 стандарт нэвтрүүлэхтэй холбогдон ажиллагаадаа сургалт хийх
- Шаардлагатай мэргэжлүүдэд 2-р шатны амтатчлалыг явуулах
- Ажиллагсдын сургалт, хөгжил, нийгмийн асуудлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх
- Компани дээр мөрдөж буй дүрэм, журам, ажлын байрны тодорхойлолтыг ISO стандарт нэвтрүүлэхтэй холбогдуулан шинэчлэх
- Ажлын байрны сургалтыг зохион байгуулах, сургалтын хөтөлбөр гаргах, ажлах хүчний залгамж халааг бэлтгэх, мэргэжлийн сургуультай хамтран ажиллах, урт хугацааны хөтөлбөр боловсруулах
- Ажиллагсдын нийгмийн асуудалд мөрдөж буй журмын хүрээнд дэмжлэг үзүүлэх

ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛТ: Эко-ногоон хөгжил, эрүүл орчин, эрүүл хүнс чиглэлээр:

- Бүтцийн орчинд ногоон байгууламж, үзлэгжүүлэх, цэцэрлэгжүүлэх тохижилтыг ажил хийх
- Зочны үйлчилгээнд эрүүл, аюулгүй, тайван орчныг бүрдүүлж өгөх, ногоон тошго авах

- Эрүүл, бамбагатай хүнсний бүтээгдэхүүнээр зочинд үйлчлэх

- Цахилгаан бага хэрэгслэдэг эсрэг чийдэн, төхөөрөмж ашиглах

- Ногоон санамжийн хуудсыг дагуу цагаан хэрэглэлийг солих

- Үсны хэрэглээ, цэвэрлэгээний бодисын хэрэглээг зохистой болгох

- Байгаль ээлтэй хэвлэмэл материал болон уут, торыг ашиглах

ТАВДУГААР ЗОРИЛТ: Компаний хамтын ажиллагаа, харуцлага:

- Хувьцаа эзэмшигчтэй харилцаатай ажиллах, уулзалт хийх, ээлжит хурал зохион байгуулах, санал хүсэлтийг шийдэх
- Нийгэмд чиглэн зохион байгуулах ажилдаа оролцох, хамтран ажиллах

- Спорт, урлагийн арга хэмжээ, зохион байгуулж ажиллах
- Компаний зорилго зорилтыг хэрэгжүүлэхэд дотоод хяналтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан батлуулж мөрдөх
- Ахмадын зөвлөл, залуучуудын зөвлөл, эмэгтэйдүүдийн зөвлөл зэрэг ОНБ-ын ажлыг идэвхжүүлэн хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу тайланга ажлынхаар хэлэлцүүлэн, дэмжиж хамтран ажиллах
- ҮЭ-ийн байгууллагатай хамтын гэрээгээ дүгнэж, ҮЭ-ийн тайланг хэлэлцэх

ЗҮРГААДУГААР ЗОРИЛТ : Хөрөнгө оруулалт, тохижилтын ажил хийнэ:

- Зочны үйлчилгээнд нийцсэн их засвар, тохижилтын ажил хийх, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх
- Шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, шинээр худалдан авах
- Бүтэйн гадна тохижилт, рестораны фасад, гарц, реклам чимэглэл, дулаан сانتехниккийн шинэчлэл засвар хийх
- Зочны аюулгүй байдлыг заруулан камерийн шинэчлэлийг үе шатай хийх
- Төлөвлөлийн сувгийн сонголтыг нэмэгдүүлэх, сугалын чанарыг сайжруулах

Эдийн засагч Ц.Лхагва: Баянгол Зочид Будал нь хөрөнгийн биржийн топ 20-н индекс багтдаг том компани юм. Бид 23 дахь жилдээ тогтмол ноогдол ашиг хуваарилаж байна.

2-дахь асуудал: ТҮЗ-н гишүүдийн зардал төсвийн талаар Ц.Лхагва ТҮЗ-н төсвийг дэлгэцээр задаргаат танилцуулав.

ТҮЗ-н гишүүн Б. Аюуш: Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангын талаар ТҮЗ-с өрсөн дүгнэлтийг хэлэлцэн баталдаг ёстой. ТҮЗ-с өрсөн 2018.03.26 хувьцаа эзэмшигчдийн хурлын тухай шийдвэр гаргасан энэ хурлаар үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг авч хэлэлцээд дүгнэлт өрсөн.

Үүнд:

Үндсэн үйл ажиллагааны талаар зочид бүүдлын зах зээл дээр асар их өрсөлдөөнтэй болж байгаа тухайн нөхцөлд түйцэтгэх удирдлагын зүгээс авч явуулсан менежментийн оновчтой арга хэмжээний үр дүнд компани зах зээл дээр эзлэх байр сууриа алдаагүй байна.

Мөн үнийн оновчтой бодлого явуулсан, хэмнэж болох зардлыг хэмнэж ажилласан байна. Ажилчдаа адистатчлалд оруулсан, ажилчдын хөдөлмөрийн бүтээмж өссөн байна. Энэ бүхний үр дүнд өнгөрсөн жилийнхээ түвшингээс үйл ажиллагааны ашгыг 24%-р нэмэгдүүлж чадсан.

Санхүүгийн тайлангын талаар санхүүгийн зохицуулах хорооноос эрх авсан аудитын байгууллагуудаар хувьцаат компаниуд аудит хийлгэх ёстой байдаг.

Санхүүгийн зохицуулах хорооноос эрх авсан Фискал аудит гэдэг компаниар санхүүгийн тайлангаа аудит хийлгэсэн.

Фискал аудит ХХК нь 2017.12.31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайлангын жилийн үр дүнг олон улсын стандартын дагуу үнэн бодитоор илэрхийлсэн байна гэсэн дүгнэлт өрсөн байсан.

Энэ бүгдийг үндэслэн ТҮЗ Гүйцэтгэх удирдлага 2017 оны төлөвлөгөөт зорилтоо амжилттай биелүүлж сайн ажигласан. Санхүүгийн тайланд үйл ажиглалааны болон санхүүгийн үр дүнг бодитой тусган байна гэсэн дүгнэлт гаргасан. Гэхдээ зарим нэг анхааруулга өрсөн байгаа. Үүнд: Та бүхэнд танилцуулсан жилийн үйл ажиглалааны тайланг илүү дэлгэрэнгүй, дүн шинжилгээт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн жилийн дагуу тайлангаа гаргаж танилцуулахыг үүрэг болгосон. Ингээд ТҮЗ-с 2017 оны төлөвлөгөөт зорилтоо амжилттай биелүүлж хангалттай сайн ажигласан, тайлангуудад үйл ажиглалаа санхүүгийн байдлаа бодитой тусгасан гэж үзсэн. Өрсөлдөөнт зах зээл дээр ашигтай ажиглахын тулд их сайн бодлого барьж ажигласан байна.

Иймд хурлаар хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хурлын дэгийн дагуу үг хэлэх санал гаргах хүн бүр 3 минут байгаа. Ингээд та бүхэн үг хэлэх, санал хэлэх асуудалдаа орьё.

Үг хэлж санал гаргах гишүүд нэрээ хувьцааны тоогоо хэлээрэй.

10 хувьцаа эзэмшигч Чимгээ: Аудитаар баталгаажсан тайлангаа хаана гаргасан бэ?

ТҮЗ-ын гишүүн Б.Аюуш: Өдөр тутмын сонингуудад мөн хөрөнгийн биржийн сайтад нээлттэй байгаа тэндээс үзэж болно.

1 хувьцаа эзэмшигч Цэдэвсүрэн: Хувьцаа эзэмшигч бид нарт зориулсан ямар нэгэн хөнгөлөлт урамшуулал байгаа юу?

ТҮЗ-ын гишүүн Б.Аюуш: Хувьцаа эзэмшигч нарт зориулсан хөнгөлөлтийн карт байгаа.

1 хувьцаа эзэмшигч Чулуунбат: Надад санал байхгүй. Харин тайлангаас харахад энэ өрсөлдөөнтэй үед сайн ажиглаж ээ. Цаашдаа улам сайн ажиглахыг хүсье.

ТҮЗ-ын гишүүн Б.Аюуш: За өөр санал хүсэлт асуулт байна уу?

Байхгүй юу? –байхгүй байна.

ТҮЗ-ын гишүүн Б.Аюуш: Санал байхгүй бол үг хэлж, санал гаргах асуудлаа таслах уу?

Санал нэгтэй тасаллаа.

ТҮЗ-ын гишүүн Б.Аюуш: За тооллогын комисс ажигладаа орьё. Саналын хайрцагаа хоосон эсэхийг харуулаад лавдаж санал хурааж эхлээ. Тооллого явагдаж дууссаны дараа

Тооллогын комиссын дарга Т.Бичигмаа: Тооллогын мэдээг танилцуулна.

Тооллогын комиссын дарга Т.Бичигмаа тооллого явагдаж дууслаа та бүхэнд тооллогын дүнг танилцуулъя. Үүнд:

Хэлэлцсэн асуудлын дараалалаар

1. 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх TV3-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлаар нийт өрсөн саналын тоо 305,328 үүнээс зөвшөөрсөн 303,847, татгалзсан 5, татгалзсан 321 байна. Нийт саналын эрхийн 99.5% ийн саналаар уг шийдвэрийг баталсан байна.
2. TV3-ын төсвийг батлах асуудлаар зөвшөөрсөн 303,727 санал, татгалзсан 1 санал, татгалзсан 340 саналаар баталаа.
3. TV3-ын энгийн гишүүдийг сонгох санал хураалтаар дараах байдалтай санал авсаныг хүн нэг бүрээр танилцуулья. Үүнд:

TV3-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигч

- Х.Баттул
- Бигли Лим Син Пау
- М.Золжаргал
- Ц.Хэнмэдэх
- Х.Цэндбаяр
- З.Цэрэнчимэг

TV3-ын хараат бус гишүүдэд нэр дэвшигч

- Б.Аюуш
- Д.Батжаргал
- Д.Цэнддэж

304,425 санал
304,159 санал
304,062 санал
304,050 санал
304,213 санал
304,100 санал
304,186 санал
304,218 санал
304,090 саналаар тус тус сонгогдсон байна.

TV3-ын гишүүн Аюуш: Хуралдаа хүрэлцэн ирж идэвхитэй оролцсон та бүхэндээ баярлалаа. Сайн сайхныг хүсье.

Хурал 18.10 минутанд дуусав.

Хурлын дарга:

Б.Аюуш

Редакцийн комисс:

М.Одонтуулгалаг

М.Уянга

